



**“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЭРТ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ,
АЧ ХОЛБОГДОЛ, ЧИГ ХАНДЛАГА” ОНОЛ, ПРАКТИКИЙН
БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ**

Хугацаа:
2025 оны 5 дугаар сарын 12 -ны өдөр

Зохион байгуулагдах газар:
Улаанбаатар хот

Зохион байгуулагч:
ОБЕГ-ЫН ДЭРГЭДЭХ Гамшиг судлалын үндэсний хүрээлэн
Монголын Улаан Загалмай Нийгэмлэг

Нэг. Үндэслэл

Гамшигийн эрсдэлийг бууруулахад эрт хариу арга хэмжээ авах, гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг нэмэгдүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшигийн удирдлага түүний тогтолцоог бэхжүүлэх, сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, байгаль, цаг уурын аюулд өртөхөөс сэргийлэх, өртсөн тохиолдолд тэсч гарах, бэлэн байдлыг хангахад эрт хариу арга хэмжээ авах нь хамгийн оновчтой үйл ажиллагаа болохыг олон туршлагаас харж болохоор байна.

Олон улсад эрт арга хэмжээ буюу “anticipatory action” гэсэн ойлголтыг ашиглаж үйл ажиллагаандaa нэвтрүүлсэнээр хохирлыг бодитой бууруулах боломжыг бий болгож байна. Аюулын шинж чанараас хамааран урьдчилан таамаглаж, түүний үндсэн дээр хариу арга хэмжээг амдаж авах үйл явц юм. Энэ нь хямралын үеийн нөлөөллийг бууруулдаг цаг хугацаа, санхүү хэмнэх, гамшигийн дараах сэргээн босгох үйл ажиллагааны үеийн нүүлгэн шилжүүлэх, өвчин эмгэг

тусах, амьжиргаагаа алдахаас урьдчилан сэргийлэх мөн нэрвэгдсэн хүмүүсийн сэтгэл зүй хүндээр гэмтэх эрсдэлүүдийг бууруулдаг олон ач холбогдолтой.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулинд энэ үйл ажиллагааг зохицуулсан заалт нь дотоодын болон гадаадын гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн үйл ажиллагааны зохицуулалтаас өөрөөр тусгагдаагүй байна.

Цаашид эрт хариу арга хэмжээ авах эрх зүйн орчныг сайжруулж, үндэсний хэмжээний зохион байгуулалтыг илүү оновчтой болгох хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Энэхүү онол, практикийн бага хурлыг Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Монголын Улаан загалмай нийгэмлэг хамтран 10 дахь удаагаа зохион байгуулж байгаа ба энэ удаа Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн 20 жилийн ой, олон улсын хүмүүнлэгийн өдрийг тохилдуулан хийж байгаагаараа онцлог юм.

Хоёр. Зорилго

Гамшгийн эрсдэлийг бууруулахад эрт хариу арга хэмжээний олон улсын болон дотоодын туршлагад тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх арга замыг шинжлэх ухааны үндэстэй дэвшүүлэн тавьж, хэлэлцэх, бодлогын болон практик санал, зөвлөмж гаргаж, холбогдох талуудад хүргүүлнэ.

Гурав. Хурлаар хэлэлцэх асуудлуудын ерөнхий чиглэл

- Гамшгаас хамгаалах хариу арга хэмжээний төрөл, нэр томъёоны асуудал
- Гамшгаас хамгаалах хариу арга хэмжээний олон улсын чиг хандлага
- Байгалийн аюулт үзэгдлийн мэдээлэлд суурилсан эрт арга хэмжээ
- Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах эрт арга хэмжээ авах эрхзүйн болон тогтолцооны чадавх
- Гамшгаас хамгаалах эрт хариу арга хэмжээний туршлага, чиг хандлага /тодорхой гамшгийн жишээн дээр/
- Гамшгаас хамгаалах эрт хариу арга хэмжээ авах инновацлаг аргууд
- Эрт хариу арга хэмжээ авахад хамтын ажиллагаа, түншлэлийн асуудал
- Гамшгаас хамгаалах эрт хариу арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалт

Дөрөв. Хурлын зохион байгуулалт

Хурлын удирдамжид заасан чиглэлийн хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн, судлаач, судлаачдын баг, их, дээд сургуулийн оюутнууд, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд оролцох боломжтой.

Бүтээлээ эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр 2025 оны 4 дүгээр сарын 26-ны дотор nidr@nema.gov.mn цахим хаягаар болон 51-262539, 51-263549 дугаараар холбогдож ирүүлнэ.

Ирүүлсэн бүтээлийг онол, практикийн бага хуралд хэлэлцүүлэх, эмхэтгэлд хэвлүүлэх гэсэн хэлбэрээр шалгаруулна. Хуралд хэлэлцүүлэх бүтээлийг урьдчилан мэдэгдэх бөгөөд хэлэлцүүлэх илтгэлээ Power point програм дээр хийж 10-15 минутад багтааж илтгэхээр бэлтгэнэ.

Тав. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага

Бүтээлийг А4 хэмжээтэй цаасны 8-12 нүүрэнд багтаан дараах хэлбэрээр бичиж ирүүлнэ.

- Хэрэглээний программ: Microsoft Word
- Үсгийн фонд: Arial
- Бичвэрийн өндөр: 12
- Мөр хоорондын зай: 1.15
- Хуудасны дээд талаас-2 см, доод талаас-2 см, зүүн талаас-3 см, баруун талаас -1.5 см

Эрдэм шинжилгээний өгүүлэл дараах хэсгүүдтэй байна. Үүнд:

- а. Өгүүллийн нэр
- б. Зохиогчийн овог, нэр, хаяг
- в. Хураангуй
- г. Түлхүүр үг
- д. Оршил
- е. Судалгааны материал, арга зүй
- ё. Судалгааны үр дүн
- ж. Хэлэлцүүлэг
- з. Дүгнэлт
- и. Ном зүй